**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН**

# ТОГТООЛ

2022 оны 06 сарын 30 өдөр　　　　Дугаар 226　　　　Улаанбаатар хот

## Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, 2022 оны 204 дүгээр тогтоолын 1, 2 дахь заалт, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн өмчит хуулийн этгээдээс татан төвлөрүүлсэн нийт 1,381,691,220.00 (нэг тэрбум гурван зуун наян нэгэн сая зургаан зуун ерэн нэгэн мянга хоёр зуун хорин) төгрөгийн балансын үнэ, 853,721,800.38 (найман зуун тавин гурван сая долоон зуун хорин нэгэн мянга найман зуун төгрөг гучин найман мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Засгийн газрын автобааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг, хавсралтад заасан хуулийн этгээдийн дарга, захирал нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Автомашиныг улсын бүртгэлээс шилжүүлж, арга хэмжээний биелэлтийг 2022 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА　　　　Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ, АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА　　　　Д.НАРАНГЭРЭЛ

132002678

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн
226 дугаар тогтоолын хавсралт

# "ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ" УЛСЫН ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

| Д/д | Шилжүүлэн өгөх хуулийн этгээдийн нэр | Автомашины нэр, марк | Улсын бүртгэлийн | | Үйлдвэрлэсэн/ ашиглалтад орсон он | | Балансын үнэ /төгрөг/ | Хуримтлагдсан элэгдэл /төгрөг/ | Үлдэгдэл өртөг /төгрөг/ | Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг) | Цаашид ашиглах хугацаа (жил) |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Сери | Дугаар | | | | | | | |
| 1 | Эрчим хүчний зохицуулах хороо | Ланд крүйзер 200 | УБО | 11-69 | 2017 | 2017 | 155,000,000.00 | 87,187,499.82 | 67,812,500.18 | | |
| 2 | Эрчим хүчний зохицуулах хороо | Ландкрүйзер 149 Прадо | УБҮ | 75-65 | 2018 | 2018 | 140,400,000.00 | 68,737,500.00 | 71,662,500.00 | | |
| 3 | Жижиг дунд үйлдвэрийн газар | Ландкрузейр-200 | УБА | 87-95 | 2019 | 2020 | 172,600,000.00 | 71,916,666.60 | 100,683,333.40 | | |
| 4 | Монгол Улсын Хөгжлийн банк | Тоёота Ланд Крүйзер-200 | УНЯ | 93-70 | 2014 | 2014 | 176,000,000.00 | 135,862,222.22 | 40,137,777.78 | | |
| 5 | Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар | Тоёота Ланд крүйзер 200 | УНҮ | 03-50 | 2013 | 2013 | 159,800,000.00 | 159,800,000.00 | - | 30,000,000.00 | 2 |
| 6 | Автотээврийн үндэсний төв | Ланд крүйзер-200 | УБҮ | 08-05 | 2011 | 2011 | 30,000,000.00 | 30,000,000.00 | - | 30,000,000.00 | 2 |
| 7 | Ашигт малтмал, газрын тосны газар | Тоёота Ланд крүйзер-200 | УБН | 68-94 | 2011 | 2012 | 76,140,040.00 | 76,140,040.00 | - | 30,000,000.00 | 2 |
| 8 | Эрчим хүчний хөгжлийн төв ТӨҮГ | Тоёота Ландруйзер -200 | УБЗ | 44-03 | 2017 | 2017 | 150,000,000.00 | 104,267,458.47 | 45,732,541.53 | | |
| 9 | Үндэсний аудитын газар | Ниссан патрол-Y62 | УАК | 05-78 | 2019 | 2020 | 170,000,000.00 | 29,547,619.10 | 140,452,380.90 | | |
| 10 | Эрүүл мэндийн яам | Ланд крүйзер 200 | УБЗ | 05-53 | 2012 | 2012 | 37,500,000.00 | 14,843,750.00 | 22,656,250.00 | | |
| 11 | Эдийн засаг, хөгжлийн яам | Тоёота Ланд крүйзер 200 | УНЕ | 15-28 | 2014 | 2014 | 42,362,330.00 | 3,530,194.17 | 38,832,135.83 | | |
| 12 | Барилга, хот байгуулалтын яам | Тоёота Ланд крүйзер 200 | УБЯ | 09-88 | 2010 | 2016 | 71,888,850.00 | 71,888,850.00 | - | 30,000,000.00 | 2 |
| Нийт дүн | | | | | | | **1,381,691,220.00** | **853,721,800.38** | **527,969,419.62** | **120,000,000.00** | **-** |
| | | | | | | | **(нэг тэрбум гурван зуун наян нэгэн сая зургаан зуун ерэн нэгэн мянга хоёр зуун хорин)** | **(найман зуун тавин гурван сая долоон зуун хорин нэгэн мянга найман зуун төгрөг гучин найман мөнгө)** | **(таван зуун хорин долоон сая есөн зуун жаран есан мянга дөрвөн зуун арван есөн төгрөг жаран хоёр мөнгө)** | **(нэг зуун хорин сая)** | - |